# ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 01 сарын 20 өдөр Дугаар 18 Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа сунгах,
үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 7.1 дэх заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1.Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч цаашид ашиглаж болох 4 нэрийн нийт 579,304,720.00 (таван зуун далан есөн сая гурван зуун дөрвөн мянга долоон зуун хорин) төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, нийт үнийг 273,000,000.00 (хоёр зуун далан гурван сая) төгрөгөөр хавсралтад заасны дагуу шинэчлэн тогтоохыг зөвшөөрсүгэй.

2.Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Нандинжаргалд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасны дагуу хөрөнгийн ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоох ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2022 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА Д.НАРАНГЭРЭЛ

132001081

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2022 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн
18 дугаар тогтоолын хавсралт

**УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, ҮЛДЭХ ӨРТӨГГҮЙ, АШИГЛАЛТЫН ХУГАЦААГ СУНГАХ, ҮНИЙГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

| Д/д | Автомашины нэр, марк, улсын дугаар, арлын дугаар | Үйлдвэрлэсэн/ ашиглалтад орсон он | Балансын үнэ | Хуримтлагдсан элэгдэл | Үлдэгдэл өртөг | Шинэчлэн тогтоосон үнэ | Цаашид ашиглах хугацаа |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | (төгрөг) | | | | (жил) |
| 1 | Тоёота Лексус LX570, УБЯ 23-00, JTJHY00W4D4126096 | 2013/2013 | 215,000,000.00 | 215,000,000.00 | - | 124,000,000.00 | 3 |
| 2 | Тоёота Лексус LX570, УНҮ 01-31, JTJHY7AX6B4083068 | 2011/2013 | 176,894,720.00 | 176,894,720.00 | - | 90,100,000.00 | 3 |
| 3 | Хьюндай Соната 7, УБҮ 03-84, KMHEB41ABDA566314 | 2013/2013 | 47,200,000.00 | 47,200,000.00 | - | 14,200,000.00 | 3 |
| 4 | Мерседес Бенз c350, УБМ 06-20, WDD2211821A529717 | 2013/2013 | 140,210,000.00 | 140,210,000.00 | - | 44,700,000.00 | 3 |
| **Нийт дүн** | | | **579,304,720.00** | **579,304,720.00** | **-** | **273,000,000.00** | - |
| | | | **(таван зуун далан есөн сая гурван зуун дөрвөн мянга долоон зуун хорин)** | | | **(хоёр зуун далан гурван сая)** | - |